



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН АКАДЕМИ ДЭЭД СУРГУУЛИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/117/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккурэйт финанс Аудит ХХК
Захирал: Ж.Оюунбилэг
Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.3 Албан шаардлага	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН АКАДЕМИ
ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.УРАНЧИМЭГ ТАНАА

2022.03.15 № 07/525
танай _____-ны № _____-г
Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_KheregiYawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar - 6.Docx

001050738

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	480,629,560.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	268,075,529.11
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	29,374.82
31110	Төгрөг	0.00	29,374.82
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	268,046,154.29
31210	Төгрөг	0.00	114,865,299.30
31211	Төрийн сангийн харилцах	0.00	114,865,299.30
31220	Гадаад валют	0.00	153,180,854.99
31223	Арилжааны банк дахь харилцах	0.00	153,180,854.99
33	АВЛАГА	0.00	136,632,864.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	136,482,865.41
33500	Бусад авлага	0.00	149,999.31
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	149,999.31
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	75,921,166.75
35400	Хангамжийн материал	0.00	75,921,166.75
35420	Аж ахуйн материал	0.00	544,971.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	75,376,195.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	268,849,148.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	268,849,148.24
39200	Биет хөрөнгө	0.00	241,604,708.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	160,874,757.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(55,251,878.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	5,529,333.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,147,000.01)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	232,176,830.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(175,374,398.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	98,312,276.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(52,297,828.76)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	2,718,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	6,072,344.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,549,787.88)
39217	Ном	0.00	27,541,160.00
39300	Биет бус хөрөнгө	0.00	27,244,440.04
39301	Програм хангамж	0.00	440,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(329,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	27,134,440.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	749,478,708.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	222,075,663.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	222,075,663.46
41300	Өглөг	0.00	2,591,451.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,628,604.19
41360	Бусад өглөг	0.00	962,847.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	42,829.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	920,018.00
41400	Урьдчилж орсон орлого	0.00	219,484,212.27
41440	Бусад урьдчилж орсон орлого	0.00	219,484,212.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	527,403,045.36
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	527,403,045.36
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	188,786,358.00
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	154,579,886.52
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	9,651,761.11
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	144,928,125.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	184,036,800.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	749,478,708.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0	1,131,856,022.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0	1,071,584,526.43
110	Орлогын албан татвар	0	1,071,584,526.43
1100	Хувь хүний орлогын албан татвар	0	1,071,584,526.43
110002	Үйл ажиллагааны орлого	0	1,071,584,526.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	60,271,496.01
120	Нийтлэг татварын бус орлого	0	43,321,496.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	34,965,978.57
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	34,965,978.57
120009	Бусад орлого	0	8,355,517.44
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	16,950,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	0	16,950,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0	986,808,108.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	986,808,108.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	981,973,108.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	526,683,406.76
210101	Үндсэн цалин	0	454,420,544.26
210105	Гэрээт ажлын хөлс	0	72,262,862.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	72,096,136.10
210201	Тэтгэврийн даатгал	0	50,654,387.45
210202	Тэтгэмжийн даатгал	0	5,627,315.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	4,364,093.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0	1,017,582.95
210205	Эрүүл мэндийн даатгал	0	10,432,756.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	37,784,527.42
210301	Гэрэл, цахилгаан	0	11,741,308.53
210302	Түлш, халаалт	0	15,957,021.55
210303	Цэвэр, бохир ус	0	9,813,707.34
210304	Байрны түрээс	0	272,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	34,973,917.52
210401	Бичиг хэрэг	0	4,319,270.01
210402	Тээвэр, шатахуун	0	1,476,540.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	9,664,319.51
210404	Ном, хэвлэл	0	9,111,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	145,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	9,936,988.00
2105	Нормативт зардал	0	185,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	9,318,160.00
210604	Урсгал засвар	0	9,318,160.00
2107	Томилолт, зочны зардал	0	791,843.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	791,843.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	47,562,793.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	47,374,196.54
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	188,596.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	252,577,324.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	64,519,944.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	101,617,733.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0	86,439,646.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	4,835,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	4,835,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	4,835,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0	145,047,914.03
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	24,465.27
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	24,465.27
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	144,253.89
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0	144,253.89
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0	144,928,125.41

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	188,786,358.00	184,036,800.84	9,651,761.11	382,474,919.95
19	Тайлант үеийн үр дүн	0	0	144,928,125.41	144,928,125.41
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	188,786,358.00	184,036,800.84	154,579,886.52	527,403,045.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0	1,198,393,483.81
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0	988,787,486.67
110	Орлогын албан татвар	0	988,787,486.67
1100	Хувь хүний орлогын албан татвар	0	988,787,486.67
110002	Үйл ажиллагааны орлого	0	988,787,486.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	139,892,514.86
120	Нийтлэг татварын бус орлого	0	139,892,514.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	139,892,514.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	34,957,563.96
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	0	104,934,950.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0	69,713,482.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	69,713,482.28
131002	Хаагдсан данс	0	32,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0	37,713,482.28
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	924,150,905.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	924,150,905.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	919,315,905.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	525,905,815.13
210101	Үндсэн цалин	0	453,642,952.63
210105	Гэрээт ажлын хөлс	0	72,262,862.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	63,740,618.68
210201	Тэтгэврийн даатгал	0	47,832,187.38
210202	Тэтгэмжийн даатгал	0	2,805,115.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	2,166,812.37
210204	Ажилгүйдлийн даатгал	0	503,746.74
210205	Эрүүл мэндийн даатгал	0	10,432,756.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	37,784,527.42
210301	Гэрэл, цахилгаан	0	11,741,308.53
210302	Түлш, халаалт	0	15,957,021.55
210303	Цэвэр, бохир ус	0	9,813,707.34

210304	Байрны түрээс	0	272,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	30,780,789.51
210401	Бичиг хэрэг	0	3,652,770.00
210402	Тээвэр, шатахуун	0	1,390,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	9,664,319.51
210404	Ном, хэвлэл	0	10,955,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	4,798,200.00
2105	Нормативт зардал	0	185,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	10,238,160.00
210604	Урсгал засвар	0	10,238,160.00
2107	Томилолт, зочны зардал	0	791,843.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	791,843.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	44,319,593.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	44,130,996.53
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	188,596.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	205,569,557.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	62,585,629.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	142,983,928.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	4,835,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	4,835,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	4,835,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	274,242,578.72
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	6,039,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	6,039,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	6,039,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	6,039,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	(6,039,700.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	(127,349.61)

14	Бусад эх үүсвэр	0	16,904.28
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	16,904.28
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	144,253.89
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0	144,253.89
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	268,075,529.11
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	268,075,529.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,136,111,415.00	930,594,774.99	205,516,640.01	81.91
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,136,111,415.00	930,450,521.10	205,660,893.90	81.90
210	Бараа, үйлчилгээний зардал	1,129,363,157.00	925,615,521.10	203,747,635.90	81.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,604,811.50	525,905,815.13	140,698,996.37	78.89
210101	Үндсэн цалин	516,749,344.00	453,642,952.63	63,106,391.37	87.79
210105	Гэрээт ажлын хөлс	149,855,467.50	72,262,862.50	77,592,605.00	48.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,080,623.00	63,740,618.68	19,340,004.32	76.72
210201	Тэтгэврийн даатгал	56,494,823.65	47,832,187.38	8,662,636.27	84.67
210202	Тэтгэмжийн даатгал	6,646,449.85	2,805,115.47	3,841,334.38	42.20
210203	ҮОМШӨ ний даатгал	5,317,159.88	2,166,812.37	3,150,347.51	40.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,329,289.97	503,746.74	825,543.23	37.90
210205	Эрүүл мэндийн даатгал	13,292,899.65	10,432,756.72	2,860,142.93	78.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,340,000.00	37,784,527.42	2,555,472.58	93.67
210301	Гэрэл цахилгаан	12,420,000.00	11,741,308.53	678,691.47	94.54
210302	Түлш, халаалт	20,400,000.00	15,957,021.55	4,442,978.45	78.22
210303	Цэвэр, бохир ус	6,320,000.00	9,813,707.34	(3,493,707.34)	155.28
210304	Байрны түрээс	1,200,000.00	272,490.00	927,510.00	22.71
2104	Хангамж, бараа материалын зардал	66,534,062.50	40,525,893.51	26,008,168.99	60.91
210401	Бичиг хэрэг	5,471,000.00	3,652,770.00	1,818,230.00	66.77
210402	Тээвэр (шатахуун)	2,450,000.00	1,390,500.00	1,059,500.00	56.76
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	15,093,312.50	9,664,319.51	5,428,992.99	64.03
210404	Ном, хэвлэл	27,865,000.00	10,955,000.00	16,910,000.00	39.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	320,000.00	(320,000.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	7,870,000.00	4,798,200.00	3,071,800.00	60.97
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,784,750.00	9,745,104.00	(1,960,354.00)	125.18
2105	Нормативд зардал	960,000.00	185,000.00	775,000.00	19.27
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	960,000.00	185,000.00	775,000.00	19.27
2106	Хөрөнгө, урсгал засварын зардал	27,205,000.00	16,277,860.00	10,927,140.00	59.83
210603	Үндсэн хөрөнгө худалдан авах зардал	12,900,000.00	6,039,700.00	6,860,300.00	46.82
21060302	Тоног төхөөрөмж авах зардал	12,900,000.00	6,039,700.00	6,860,300.00	46.82
210604	Урсгал засвар	14,305,000.00	10,238,160.00	4,066,840.00	71.57
21060401	Урсгал засвар /Барилга/	14,305,000.00	8,600,600.00	5,704,400.00	60.12
21060403	Урсгал засвар /эд хогшил/	-	1,637,560.00	(1,637,560.00)	-
2107	Томилолт, зочны зардал	3,571,100.00	791,843.00	2,779,257.00	22.17
210702	Дотоод албан томилолт	1,571,100.00	-	1,571,100.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	791,843.00	1,208,157.00	39.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	44,149,500.00	44,319,593.36	(170,093.36)	100.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,429,500.00	44,130,996.53	(701,496.53)	101.62
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	720,000.00	188,596.83	531,403.17	26.19
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	196,918,060.00	196,084,370.00	833,690.00	99.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,551,060.00	142,983,928.00	(26,432,868.00)	122.68
210903	Эрдэм шинжилгээний зардал	38,250,000.00	15,318,430.00	22,931,570.00	40.05
210905	Оюутны үйлчилгээний зардал	25,652,000.00	14,981,320.00	10,670,680.00	58.40
210906	Мэргэжил дээшлүүлэх	5,450,000.00	120,000.00	5,330,000.00	2.20
21090704	Дотоод тооцооны зардал	-	259,916.00	(259,916.00)	-
21090704	Дотоод гүйлгээний зардал	-	259,916.00	(259,916.00)	-

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210908	Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
210909	Зар сурталчилгааны зардал	1,785,000.00	1,794,342.00	(9,342.00)	100.52
210910	Захиргааны зардал	2,230,000.00	2,513,536.00	(283,536.00)	112.71
210911	Төвлөрсөн арга хэмжээний зардал	5,500,000.00	2,896,898.00	2,603,102.00	52.67
210912	Төсөл хөтөлбөрийн зардал	-	15,216,000.00	(15,216,000.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,748,258.00	4,835,000.00	1,913,258.00	71.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,748,258.00	4,835,000.00	1,913,258.00	71.65
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,748,258.00	4,835,000.00	1,913,258.00	71.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	144,253.89	(144,253.89)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	144,253.89	(144,253.89)	-
225004	Гадаад валют ханшийн зөрүүний гарз	-	144,253.89	(144,253.89)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,136,561,415.00	1,093,735,353.19	42,826,061.81	96.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,000,000.00	69,713,482.28	(37,713,482.28)	217.85
131002	ШУТС-ийн санхүүжилт	32,000,000.00	32,000,000.00	-	100.00
131006	Боловсролын зээлийн сангийн санхүүжилт	-	37,713,482.28	(37,713,482.28)	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,104,561,415.00	1,024,004,966.63	80,556,448.37	92.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,084,476,295.00	957,763,906.67	126,712,388.33	88.32
120004108	Оюутны хөгжлийн зээлийн орлого	-	31,023,580.00	(31,023,580.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,085,120.00	23,707,563.96	(3,622,443.96)	118.04
120004201	Төслийн орлого	-	11,250,000.00	(11,250,000.00)	-
120004202	Дотоод тооцооны орлого	-	259,916.00	(259,916.00)	-
12000420204	Дотоод гүйлгээний орлого	-	259,916.00	(259,916.00)	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	16,904.28	(16,904.28)	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	16,904.28	(16,904.28)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	104,934,950.90	(104,934,950.90)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	268,075,529.11	(268,075,529.11)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	47	47	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, авлага, цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 21-ний хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Л.Баярмаа, аудитор Я.Золзаяа, аудиторын туслах А.Алтанчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтыг захирал Ж.Оюунбилэг, чанарын хяналтын менежер Л.Гоёцэцэг нар хэрэгжүүлсэн.

Дүрслэх урлагийн академи дээд сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аккурэйт финанс Аудит ХХК -д 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/47 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дүрслэх урлагийн академи дээд сургууль нь ЗГ-ын Төрийн өмчит дээд боловсролын байгууллагыг өөрчлөн байгуулах тухай 2020 оны 224 дүгээр тогтоолоор Соёл, урлагийн их сургуулиас тусгаарлагдан бие даан зохион байгуулагдсан.

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Монголчуудын уламжлалт соёл урлагийн үнэт зүйлсийг эзэмшсэн, орчин үеийн дэвшилтэт ололтод тулгуурлан уламжлал, шинэчлэлийг зохистой хослуулсан, дэлхийн соёлд хувь нэмрээ оруулах, Монголын соёлыг хүн төрөлхтний өвийн салшгүй хэсэг болгож чадах мэргэжилтэн судлаач, уран бүтээлч бэлтгэхэд оршино.

Мөн Монгол үндэстний урлахуйн уламжлалт өв соёл, дэлхий дахины урлагын хөгжлийн чиг хандлага, орчин үеийн дэвшилтэт технологи, шинжлэх ухааны онол арга зүйд суурилсан сургалт-судалгаа-уран бүтээлийн таатай орчин бүрдүүлж, улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц өргөн дэлгэр мэдлэг боловсролтой, өндөр дээд ёс суртхуунтай мэргэжилтэн бэлтгэх чиг үүрэгтэй БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны “бодлогын баримт бичиг, журам батлах тухай” А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 986.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122.0 сая төгрөгөөр өсөж, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн, буурсан
Мөнгөн хөрөнгө	104,935.0	268,075.5	163,140.6
Авлага	98,928.2	136,632.9	37,704.6
Бараа материал	74,332.0	75,921.2	1,589.2
Үндсэн хөрөнгө	349,249.1	268,849.1	(80,399.9)
Нийт хөрөнгийн дүн	627,444.2	749,478.7	122,034.5
Өр төлбөрийн дүн	244,969.3	222,075.7	(22,893.7)

/мянган төгрөг/

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	382,474.9	527,403.0	144,928.1
Засгийн газрын хувь оролцоо	382,474.9	527,403.0	144,928.1
Засгийн газрын оруулсан капитал /ЗГС/ орон нутгийн сан	188,786.4	188,786.4	-
Өмч: -Төрийн өмч	188,786.4	188,786.4	-
Хуримтлагдсан үр дүн	9,651.8	154,579.9	144,928.1
Өмнөх үеийн үр дүн	9,651.8	9,651.8	-
Тайлант үеийн үр дүн	-	144,928.1	144,928.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,036.8	184,036.8	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	627,444.2	749,478.7	122,034.5

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 163.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сургалтын төлбөрийн орлогын өсөлтөөс шалтгаалсан;
- Авлага данс сургалтын төлбөрийн авлага 37.7 сая төгрөгөөр өссөн
- Үндсэн хөрөнгө данс тайлант худалдан авсан 6.7 сая төгрөг, элэгдэлийн зардал 86.4 сая сая төгрөг
- Өр төлбөр данс байгууллагад өгөх өглөг 37.0 сая төгрөгөөр буурч, оюутны сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 16.7 сая төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,084.4 сая төгрөг, ШУТС-аас санхүүжих 32.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 20.1 сая төгрөг, нийт 1,136.5 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 1,136.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөр 1,136.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,136.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа болон, туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,093.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 930.6 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 81.9 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт тусгайлан гаргадаггүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дүрслэх урлагийн академи дээд сургууль тайлант онд нийт 27.1 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 85 мэдээллийг бүрэн байршуулж, 46 мэдээллийг хугацаа хоцроож, 61 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4 “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд Албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус сургууль нь ЗГ-ын Төрийн өмчит дээд боловсролын байгууллагыг өөрчлөн байгуулах тухай 2020 оны 224 дүгээр тогтоолоор Соёл, урлагийн их сургуулиас тусгаарлагдан бие даан зохион байгуулагдсан тул өмнөх оны болон завсрын аудитын асуудал байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.9 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 9.9 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй 9.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 9.9 сая төгрөгөөр хэтрээгүй Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.3 Албан шаардлага

Төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй дараах зардлыг гаргасан байна. Үүнд:

Боловсролын салбарын 100 жилийн арга хэмжээний зардалд 3.1 сая, хүлээн авалт бэлэг, цэцгийн үнэнд нийт 4.3 сая төгрөг, сургуулийн веб хуудас хийлгэх зардалд 2.5 сая төгрөг нийт 9.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6 заасан “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”, 1.3 заасан “цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, 1.7 заасан “хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, албан шаардлагаа өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ДУАДС	АХГ-2022/117/НА-СТА-ТӨА	Боловсролын салбарын 100 жилийн арга хэмжээний зардалд 3.1 сая өгрөгийг зарцуулсан байна.	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, албан шаардлагаа өгөх	1	3,172.1						3,172.1				
2	ДУАДС	АХГ-2022/117/НА-СТА-ТӨА	Хүлээн авалт бэлэг, цэцгийн үнэнд нийт 4.3 сая төгрөгийн орлого санхүүгийн тайланд бүртгэсэн байна.		1	4,321.6					1	4,321.6				
3	ДУАДС	АХГ-2022/117/НА-СТА-ТӨА	Сургуулийн веб хуудас хийлгэх зардалд 2.5 сая төгрөгийг зарцуулсан байна.		1	2,500.0						2,500.0				
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					3	9,993.7	-	-	-	-	1	9,993.7	-			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
3	ДУАДС	АХГ-2022/117/НА-СТА-ТӨА	Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 онд нийт 27.1 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 85	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх Албан шаардлага өгөх	1						1					

Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			мэдээллийг бүрэн байршуулж, 46 мэдээллийг хугацаа хоцроож, 61 мэдээллийг байршуулаагүй байна														
Нийцлийн аудитын дүн										1							
Нийт дүн				4	9,993.7	-	-	-	-	2	9,993.7						



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 361/А0150058

Улаанбаатар хот

АХГ- 0022/117/М.А-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын салбарын 100 жилийн арга хэмжээний зардалд 3,172,130.00 төгрөг, хүлээн авалт бэлэг, цэцгийн үнэнд нийт 4,321,673.00 төгрөг, сургуулийн веб хуудас хийлгэх зардалд 2,500.000 төгрөг нийт 9,993,803.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 заасан "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" 1.3 заасан "цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.7 заасан "хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хам олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн захирал Д.Уранчимэг, нягтлан бодогч Р.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СӨРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shardlaga\2022\0315 Auditin 2 Газар-1.Docx

0010800939



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 360/АОХС0058
АХГ-2022/117/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 27.1 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 85 мэдээллийг бүрэн байршуулж, 46 мэдээллийг хугацаа хоцроож, 61 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх урлагийн академи дээд сургуулийн захирал Д.Уранчимэг, нягтлан бодогч Р.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\0.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-2.Docx

0010800941

